

нтий аймаг дахь Төрийн  
аудитын газар

**ӨНДӨРХААН ХОТ ТОХИЖИЛТЫН 2017  
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

**Менежментийн захидал**

**Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:**

- Асуудал 1
- Төсвийн орлогын талаар .....3
- Асуудал 2
- Зардлын талаар.....4



## Менежментийн захидал

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг бэлтгэсэн менежментийн захидлыг Өндөрхаан хот тохижилтын газарт зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн анал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи өдний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Өндөрхаан хот тохижилтын захирал, талархал бодогч нарт талархал илэрхийлье.



### Г-ын ажиглалт

Өндөрхаан хот тохижилтийн газар нь иргэн, хүүхэд, ахуй нэгж байгууллагуудын хог хаягдлын үйлчилгээний хураамжийн 132.2 сая төгрөгийг нэг нутгийн төсвийн дансанд төвлөрүүлээгүй, өдрийн нэмэлт дансанд авч, зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 23.8-т “Сум дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ”, 23.8.12-ын “Хог хаягдлын үйлчилгээний хураамж”, Хог хаягдлын тухай хуулийн 41.8-ын “Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг сум, дүүргийн төсөвт төвлөрүүлнэ” гэсэн заалтыг зөрчиж, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг өгөхгүй байна.

### АГ-ын зөвлөмж

1.Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг нэмэлт дансандаа төвлөрүүлэн зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, сумын төсвийн орлогын дансанд төвлөрүүлэх

### Эрсдэлүүд

Сумын төсвийн орлогыг төвлөрүүлэхгүй байх

### Төсвийн захирагчийн хариу

Өндөрхаан хот тохижилтын газрын 2018.04.02-ны 25 –ны өдрийн 35 тоот албан бичгээр “Зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана” гэсэн болно.



**ААГ-ын ажиглалт**

Байгууллагын НДШ-ийн зардлаас ажиглагсдын цалингаас суутгасан 1.5 сая төгрөгийн НДШ-ийг төлж, зардлын зүйл ангийг зөрүүлж бүртгэн, тайлагнасан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 –ын Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулна”, Сангийн Сайдын 2015 оны 1 дүгээр сарын 20-ны 7 дугаар тушаалын 2-р хэсгээр батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал”-ыг зөрчиж, санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байдал”, “Толилуулга ба тодруулга” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Эрсдэлүүд**

Холбогдох хууль тогтоомжийг мөрдөхгүй байх

**ААГ-ын зөвлөмж**

1. Батлагдсан зардлыг өөр зардалд зарцуулан, бүртгэж тайлагнадаг зөрчлийг арилгаж, батлагдсан төсөвт зардлыг зориулалтын зардалд зарцуулах, түүнд тавих дотоодын хяналтыг сайжруулах

**Төсвийн захирагчийн хариу**

Өндөрхаан хот тохижилтын газрын 2018.04.02-ны 25 –ны өдрийн 35 тоот албан бичгээр “Зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана” гэсэн болно

**МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ**

**ХЯНАСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР



Ч.ЭРДЭНЭБААТАР

Д.ОЮУНТУЯА

**БЭЛТГЭСЭН:**

АХЛАХ АУДИТОР

Б.НАРАНЦЭЦЭГ